

МОНГОЛ УЛСЫН УУЛ УУРХАЙ
ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙДЫН ТУШААЛ

2018 оны ... дугаар
сарын өдөр

Дугаар

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5.12 дахь хэсэг, 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2.3, 5.2.5 дахь хэсэг, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.10.13 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

НЭГ. Газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөлтэй холбоотой нарийвчилсан журмыг нэгдүгээр хавсралтаар, газрын тосны бүтээгдэхүүний мэдээ, тайлан гаргах маягтуудыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

ХОЁР. Газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөлтэй холбоотой нарийвчилсан журмын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Б.Элбэгзаяа/-т үүрэг болгосугай.

ГУРАВ. Журмыг холбогдох хууль тогтоомжийн дагуу Хууль зүй, дотоод хэргийн яаманд бүртгүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар /М.Баяраа/-т даалгасугай.

САЙД

Д.СУМЪЯАБАЗАР

ГАЗРЫН ТОСНЫ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛТЭЙ ХОЛБООТОЙ НАРИЙВЧИЛСАН ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь Монгол Улсын нутаг дэвсгэрт газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхлэхэд зохицуулалт хийх, хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл шинээр олгох /цаашид “Тусгай зөвшөөрөл” гэх/, хугацааг сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох, мэдээ тайлан гаргахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2 Энэхүү журам нь Газрын тосны бүтээгдэхүүний тухай хууль, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Барилгын тухай хууль, Галын аюулгүй байдлын тухай хууль, Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай хууль, Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай хууль бусад хууль тогтоомж, эрх зүйн актуудад үндэслэж, тэдгээрт нийцсэн байна.

1.3 Нэр томъёо:

“Газрын тосны бүтээгдэхүүн” гэж Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийн 4.1.1-д заасан нэр томъёог ойлгоно.

1.4 Энэхүү журмыг газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллага, тусгай зөвшөөрөл хүсэгч, тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээд дагаж мөрдөнө.

Хоёр. Газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрлийн үйл ажиллагааны төрөл, хамрах хүрээ

2.1. Газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрлийн хүрээнд дараах үйл ажиллагаа хамрагдана.Үүнд:

2.2.1. Газрын тос боловсруулж газрын тосны бүтээгдэхүүн үйлдвэрлэх;

2.2.2. Уламжлалт бус газрын тосыг боловсруулж газрын тосны бүтээгдэхүүн үйлдвэрлэх;

2.2.3. Дахивар түүхий эд, ургамлыг боловсруулж газрын тосны бүтээгдэхүүн үйлдвэрлэх.

Гурав. Тусгай зөвшөөрөл авахад бүрдүүлэх баримт бичиг

3.1 Тусгай зөвшөөрөл хүсэгч дараах бичиг баримтыг хуулийн этгээдийн захирал /дарга/-ын гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажуулан, дугаарлан газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлнэ.

3.1.1. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийн 11.1.1, 11.1.2, 11.1.4 болон Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсгийн 8.3.1-8.3.6 дахь заалтад заасан бичиг баримт;

3.1.2. Шинжлэх ухаан, технологийн хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсэгт заасны дагуу байгуулагдсан Хүнд үйлдвэрийн салбарын шинжлэх ухаан, технологийн зөвлөлөөр хэлэлцүүлсэн зөвлөмж, дүгнэлт;

3.1.3. Санхүү, хөрөнгийн нөөц, эдийн засгийн чадавхийн талаарх мэдээлэл

3.1.4. Мэргэжлийн боловсон хүчин, тэдгээрийн дадлага туршлагын талаарх мэдээлэл

3.1.5. Газрын тос боловсруулах үйлдвэрийн усны хангамжийн талаарх мэргэжлийн байгууллагын дүгнэлт;

- 3.1.6. Түүхий тос болон бусад төрлийн түүхий эд нийлүүлэгчтэй байгуулсан гэрээ /эх хувиар/;
- 3.1.7. Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны зааварчилгаа болон сургалтын хөтөлбөр боловсруулсан байх

3.2 Тусгай зөвшөөрөл хүсэгчийн ирүүлсэн баримт бичгийн бүрдэл, ирүүлсэн бичиг баримтын үнэн зөв байдлыг газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын тусгай зөвшөөрлийн асуудал хариуцсан газар хянах ба шаардлага хангасан өргөдөл болон бичиг баримтыг хүлээн авна.

3.3 Тусгай зөвшөөрөл хүсэгчийн өргөдлийг хянах явцад зарим мэдээллийг нягтлах, баталгаажуулах шаардлага гарвал нэмэлт материал шаардаж болох ба өргөдөл гаргагч хуулийн этгээд тогтоосон хугацаанд гаргаж өгөх үүрэг хүлээнэ.

3.4 Тусгай зөвшөөрөл олгохоос татгалзсан шийдвэр гарсан бол энэ тухай өргөдөл гаргагч хуулийн этгээдэд бичгээр мэдэгдэх ба уг албан бичигт тусгай зөвшөөрөл олгохоос татгалзсан үндэслэлийг дурдсан байна.

Дөрөв. Тусгай зөвшөөрлийн хүсэлтийг үнэлэх, хянан шийдвэрлэх

4.1 Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага /УУХҮЯ/ нь тусгай зөвшөөрөл хүсэгч хуулийн этгээдийн ирүүлсэн өргөдөл болон баримт материалд магадлан шинжилгээг ажлын 5 хоногт багтаан хийж, Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага /Ашигт малтмал, газрын тосны газар/-т холбогдох материалыг үйлдвэрийн техник, технологийн талаар дүгнэлт гаргуулахаар хүргүүлнэ.

4.2 Ашигт малтмал, газрын тосны газар нь өргөдөл гаргасан хуулийн этгээдийн үйлдвэрийн техник, технологийн талаарх дүгнэлтийг ажлын 14 хоногийн дотор гаргаж, Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага /УУХҮЯам/-д хүргүүлнэ.

4.3 Тусгай зөвшөөрөл хүсэгч хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл шинээр олгоход Газрын тосны бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйлдвэрийн техник, технологийн талаарх дүгнэлт болон энэхүү журмын 3.2-т заасан баримт материалыг үндэслэн Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын шийдвэрээр бүртгэлийн гэрчилгээ олгоно.

4.4 Тусгай зөвшөөрлийн өргөдлийг үнэлэх шатанд зарим мэдээллийг нягтлах, баталгаажуулах шаардлага үүсвэл нэмэлт материал шаардаж болох ба өргөдөл гаргагч хуулийн этгээд тогтоосон хугацаанд гаргаж өгөх үүрэг хүлээнэ.

4.5 Тусгай зөвшөөрөл олгохоос татгалзсан шийдвэр гарсан бол энэ тухай өргөдөл гаргагч хуулийн этгээдэд бичгээр мэдэгдэх ба уг албан бичигт тусгай зөвшөөрөл олгохоос татгалзсан үндэслэлийг дурдсан байна.

4.6 Тусгай зөвшөөрлийн өргөдөл, баримт материалыг үнэлэх шатанд хийсэн дүгнэлтэд үндэслэн дараах нөхцөлд тусгай зөвшөөрөл олгохоос татгалзах шийдвэр гаргаж болно. Үүнд:

- 4.6.1 Тусгай зөвшөөрлийн үйл ажиллагаа явуулах техник, технологийн болон эдийн засгийн боломж, нөхцөл хангагдаагүй буюу бүрдээгүй;
- 4.6.2 Тусгай зөвшөөрлийн үйл ажиллагаа явуулах санхүүгийн чадавхгүй;
- 4.6.3 Боловсон хүчний чадавхи, хүрэлцээ шаардлага хангаагүй;
- 4.6.4 Аюулгүй ажиллагааны зохион байгуулалт, менежмент нарийн төлөвлөгдөөгүй ;
- 4.6.5 бусад үндэслэл;

4.7 Өргөдөл гаргасан хуулийн этгээдийн өргөдөлд хавсаргасан материалд магадлан шинжилгээ хийх болон газрын тос боловсруулах үйлдвэрийг газар дээр нь үзэж үнэлэлт, дүгнэлт өгөх арга хэмжээний үед гарах зардлыг өргөдөл гаргагч хариуцна.

Тав. Тусгай зөвшөөрлийн хугацаа сунгуулахад бүрдүүлэх материал

5.1. Хугацаа сунгуулах өргөдлийг холбогдох материалын хамт тусгай зөвшөөрлийн хугацаа дуусахаас хуанлийн 60 хоногийн өмнө гаргана.

5.2. Тусгай зөвшөөрлийн хугацааг сунгуулахад дараах материалыг бүрдүүлсэн байна. Үүнд:

- 5.2.1 Тусгай зөвшөөрлийн хугацааг сунгуулах тухай өргөдөл;
- 5.2.2 Тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага, хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлж байсан талаарх тайлан;
- 5.2.3 Удирдах болон мэргэжлийн инженер, техникийн ажилчдын мэдээлэл;
- 5.2.4 Сүүлийн хоёр жилийн санхүүгийн тайлан тэнцлийн талаар мэдээлэл;
- 5.2.5 Сүүлийн хоёр жилд үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүний нэр төрөл ба үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний тоо хэмжээ;
- 5.2.6 Үйлдвэрлэлийн тухайн жилийн тайлан /баталгаажуулсан/
- 5.2.7 Үйлдвэрийн технологи болон барилга байгууламжтай холбоотой шинэчлэлт, өөрчлөлт бусад үйл ажиллагааны талаарх мэдээлэл;
- 5.2.8 Улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт;
- 5.2.9 Техник эдийн засгийн үндэслэл/тодотгол хийгдсэн байх/

Зургаа. Тусгай зөвшөөрөл түдгэлзүүлэх, сэргээх

6.1 Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Газрын тосны бүтээгдэхүүний тухай хууль болон тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага зөрчлийг арилгах тухай хугацаатай үүрэг өгнө. Заасан хугацаанд зөрчлөө арилгаагүй тохиолдолд Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д заасны дагуу тусгай зөвшөөрлийг 3 хүртэл сараар түдгэлзүүлж болно.

6.2 Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага /УУХҮЯ/ нь түдгэлзүүлсэн шийдвэрийн талаар тусгай зөвшөөрөл эзэмшигч болон харьяалах татварын албанд Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2-д заасны дагуу 3 хоногийн дотор бичгээр мэдэгдэнэ.

6.3 Тусгай зөвшөөрлийн үйлчлэлийг түдгэлзүүлсэн нөхцөл арилсан тохиолдолд Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага /УУХҮЯ/-ны шийдвэрээр тусгай зөвшөөрлийг сэргээнэ.

Долоо. Тусгай зөвшөөрөл хүчингүй болгох

7.1. Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага /УУХҮЯ/ нь Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулиудад заасан дараах тохиолдолд тусгай зөвшөөрлийг хүчингүй болгоно:

- 7.1.1 тусгай зөвшөөрөл эзэмшигч хүсэлт гаргасан;
- 7.1.2 тусгай зөвшөөрлийн хугацаа дууссан;
- 7.1.3 тусгай зөвшөөрөл эзэмшигч татан буугдсан, дампуурсан;
- 7.1.4 тусгай зөвшөөрлийг хууль бусаар олж эзэмшсэн нь тогтоогдсон;
- 7.1.5 энэ журмын 6.1-д заасны дагуу тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн боловч зөрчлийг хугацаанд нь арилгаагүй;
- 7.1.6 тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг удаа дараа буюу ноцтой зөрчсөн;
- 7.1.7 байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний төлөвлөгөөг биелүүлээгүй буюу байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомж зөрчсөн;

7.2 Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага /УУХҮЯ/ нь тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох тухай мэдэгдлийг тусгай зөвшөөрөл эзэмшигчид өгснөөс хойш 30 хоногт багтаан хүчингүй болгосон шийдвэр гаргана.

7.3 Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон тухай шийдвэрийн талаар Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага /УУХҮЯ/ нь Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-д заасны дагуу шийдвэр гарснаас хойш 3 хоногийн дотор тусгай зөвшөөрөл эзэмшигч болон

харьяалах татварын албанд бичгээр мэдэгдэнэ.

7.4 Тусгай зөвшөөрлийн хүчингүй болсон нь түүнийг эзэмшигч хуулийн этгээдийн байгаль орчныг нөхөн сэргээх болон бусад үүргээс чөлөөлөгдөх үндэслэл болохгүй.

Найм. Хориглох үйл ажиллагаа

- 8.1 Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь дараах үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно.
- 8.1.1 Тусгай зөвшөөрлийг бусдад шилжүүлэх;
 - 8.1.2 Тусгай зөвшөөрлөөр олгогдсон эрхээ хууль бусаар ашиглах;
 - 8.1.3 Газрын тосны бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйл ажиллагаа эрхлэхдээ бусад тусгай зөвшөөрөл эзэмшигч, хэрэглэгчдийг ялгаварлан гадуурхах;
 - 8.1.4 Газрын тосны бүтээгдэхүүн үйлдвэрлэх тусгай зөвшөөрлөөр эрхэлж байгаа үйл ажиллагаанд хор хохирол, аюул эрсдэл учруулж болохуйц бусад үйл ажиллагаа эрхлэх;

Ес. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үүрэг

- 9.1 Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийн 8.4.1-т заасны дагуу үндэсний стандартад нийцсэн газрын тосны бүтээгдэхүүн үйлдвэрлэх;
- 9.1 Үйл ажиллагаагаа өргөтгөх, шинэчлэх зэрэг аливаа өөрчлөлтийг Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тухай бүр албан ёсоор мэдэгдэх, тайлагнах;
- 9.2 Мэдээ тайланг маягт 1-4 дагуу сар бүрийн 5-ны дотор эрх бүхий албан тушаалтны гарын үсгээр баталгаажуулан албан бичгээр Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх;
- 9.3 Төрийн эрх бүхий байгууллагаас шаардсан бусад холбогдох мэдээ, тайланг заасан хугацаанд нь түргэн шуурхай, үнэн зөв гаргаж хүргүүлэх.
- 9.4 Тусгай зөвшөөрөл авсанаас хойш үйл ажиллагаагаа эхлүүлэхээс өмнө үйлдвэрлэлийг улсын комисст хүлээлгэж өгөх. /комисс ажиллах эрхзүйн орчинг бүрдүүлэх шаардлагатай/

Арав. Хяналт

- 10.1 Тусгай зөвшөөрөл авсан хуулийн этгээдийн тусгай зөвшөөрлөөр олгогдсон эрх, үүргийн биелэлт, хэрэгжилтэд Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төлөөлөл хяналт тавина.
- 10.2 Шаардлагатай тохиолдолд Онцгой байдлын ерөнхий газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын эрх бүхий ажилтантай хамтран хяналт, үзлэг шалгалтыг зохион байгуулж ажиллана.
- 10.3 Хяналт тавих эрх бүхий байгууллагуудын төлөөлөгчийг тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээд нь өөрийн эзэмшлийн үйлдвэрийн барилга, байгууламж, объект, агуулах, түгээх станцад саадгүй нэвтрүүлж, үзлэг шалгалт хийх нөхцөл боломжоор хангана.

Маягт 1

Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний мэдээ

ААН-ийн нэр:

Тайлант хугацаа: 20..... оны-р сарын-с 20..... оны-р сарын өдөр

№	Нэр төрөл	Тоо, хэмжээ	Чанарын үзүүлэлтүүд,	Үнэ
1				
2				
3				
4				

Дарга / Захирал/ / Овог нэр/
Тэмдэг гарын үсэг

Маягт 2

Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний борлуулалтын мэдээ

ААН-ийн нэр:

Тайлант хугацаа: 20..... оны-р сарын-с 20..... оны-р сарын өдөр

№	Нэр төрөл	Тоо, хэмжээ	Чанарын үзүүлэлтүүд,	Үнэ
1				
2				
3				
4				

Дарга / Захирал/ / Овог нэр/
Тэмдэг гарын үсэг

Маягт 3

**Газрын тосны бүтээгдэхүүний
агуулахын үлдэгдлийн мэдээ**

ААН-ийн нэр:

Тайлант хугацаа: 20..... оны-р сарын-с 20..... оны-р сарын өдөр

Агуулахын үлдэгдэл /тн/						Агуулахын үнэ төг/литр				
Н-80	Р-92	П-95, 98	ДТ	ШШХ	ОТ	ШШХ	Н-80	Р-92	П-95, 98	ДТ

ШШХ- Шингэрүүлсэн шатдаг хий, ОТ- Онгоцны түлш

Анхаарах:

1. Үлдэгдлийн тайланг долоо хоног бүрийн Мягмар гарагт гаргаж УУХҮЯ-ны эрх бүхий албан тушаалтны гарын үсгээр баталгаажуулан /УУХҮЯ/-нд хүргүүлнэ.
2. Үлдэгдэл, үнийг тухайн өдрийн дүнгээр шивнэ.
3. Тайлант хугацааны эцсийн үлдэгдэл нь тухайн агуулахад хадгалагдаж байгаа үлдэгдэл болно.

Дарга / Захирал/ / Овог нэр/
гарын үсэг

Тэмдэг

Маягт 4

Түүхий тосны агуулахын үлдэгдлийн мэдээ

ААН-ийн нэр:

Тайлант хугацаа: 20..... оны-р сарын-с 20..... оны-р сарын өдөр

Агуулахын үлдэгдэл /тн/				Агуулахын үнэ тн/төг			
1 долоо хоног	2 долоо хоног	3 долоо хоног	4 долоо хоног	1 долоо хоног	2 долоо хоног	3 долоо хоног	4 долоо хоног

Анхаарах:

1. Үлдэгдлийн тайланг долоо хоног бүрийн Мягмар гаригт гаргаж УУХҮЯ-ны эрх бүхий албан тушаалтны гарын үсгээр баталгаажуулан хүргүүлнэ.
2. Үлдэгдэл, үнийг тухайн өдрийн дүнгээр шивнэ.
3. Тайлант хугацааны эцсийн үлдэгдэл нь тухайн агуулахад хадгалагдаж байгаа үлдэгдэл болно.

Дарга / Захирал/ / Овог нэр/

Мэдээ тайлан ирүүлэх хуваарь

№	Мэдээллийн нэрс	Хугацаа	Танилцуулах албан тушаалтан
1	Газрын тосны бүтээгдэхүүний үлдэгдэл нөөцийн мэдээ	7 хоног бүрийн 2 дахь өдөр	УУХҮЯ
2	Газрын тосны бүтээгдэхүүний бөөний үнийн мэдээ, төг /агуулах, хот, аймгаар/	7 хоног бүрийн 2 дахь өдөр	УУХҮЯ, ҮАБЗөвлөл, ТЕГ, ШӨХТГ
3	Газрын тосны бүтээгдэхүүний бөөний борлуулалтын мэдээ	Сар бүрийн 5-ны дотор	УУХҮЯ ҮАБЗөвлөл, ТЕГ, ШӨХТГ
4	Бөөний борлуулалтын тайланг тухай сар бүрээр гаргаж эрх бүхий албан тушаалтны гарын үсгээр баталгаажуулан хүргүүлнэ.	Сар бүрийн 5-ны дотор	УУХҮЯ ҮАБЗөвлөл, ТЕГ, ШӨХТГ
5	Түүхий тосны захиалгын мэдээ	Сар бүрийн 5-ны дотор	УУХҮЯ, ҮАБЗөвлөл, ТЕГ, ШӨХТГ
6	Компанийн түүхий тосны нөөцийн мэдээ	Сар бүрийн 5-ны дотор	УУХҮЯ, ҮАБЗөвлөл, ТЕГ, ШӨХТГ

ГАЗРЫН ТОСНЫ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛТЭЙ ХОЛБОГДСОН ХАРИЛЦААГ ЗОХИЦУУЛАХ НАРИЙВЧИЛСАН ЖУРМЫН ТАНИЛЦУУЛГА

Монгол улсын “Газрын тосны бүтээгдэхүүний” тухай хууль болон “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн” тухай хуулийг үндэслэн “Газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл”-ийг Газрын тосны асуудал эрхэлсэн Төрийн захиргааны төв байгууллага олгох бөгөөд тусгай зөвшөөрөлтэй холбоотой нарийвчилсан журмыг баталж мөрдүүлэх гэж заасан байдаг.

Энэхүү хуулийн хэрэгжилтийг хангах, аж ахуй нэгжүүдийг дэмжих зорилгоор 2004 оноос эхлэн дотоод, гадаадын компаниудаас Монгол Улсад газрын тос боловсруулах үйлдвэр байгуулахаар ирүүлсэн бизнес төслүүд болон техник, эдийн засгийн үндэслэлийг үндэслэн өнөөдрийн байдлаар нийт 18 тусгай зөвшөөрөл олгосон байна.

Өнөөдрийн байдлаар Эрдэнэт хотод байрлах “Петролеум продакшн” ХХК-ийн жилд 50 мянган тонн хийн конденсат боловсруулж газрын тосны бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйлдвэр болон “Алтан оршихуй” ХХК-ийн Багахангай дүүрэгт байрлах дахивар түүхий эдийг дахин боловсруулж жилд 6000 тонн газрын тосны бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйлдвэрүүдийг эс тооцвол бусад тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн газрын тос боловсруулах үйлдвэрийн төсөл хэрэгжээгүй байна.

Тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуй нэгжүүдээс 2015 онд хугацаа нь дууссан 2, 2016 онд хугацаа нь дуусах 6, 2017-2018 онд хугацаа нь дуусах 5 тусгай зөвшөөрөл тус тус бүртгэгдсэн байна.

Газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах төслүүдийг ерөнхийд нь дүгнэвэл үйлдвэр байгуулах хөрөнгө, санхүүжилтийн асуудал нь тодорхой бус шийдэгдээгүй түүнчлэн техник, технологийн сонголт бүрэн хийгдээгүй зэрэг асуудлуудтай байна.

Өмнөх жилүүдэд “Газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл”-үүд нь зохицуулалт хийх нарийвчилсан журамгүй олгогдсоны улмаас тусгай зөвшөөрлийн хүрээнд хийгдсэн ажлын хэрэгжилтэд хяналт тавих боломжгүй байдал үүсдэг байсан.

Иймд Монгол Улсад байгуулах Газрын тосны бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйлдвэрийг холбогдох хууль, тогтоомж, Төрөөс баримталж буй бодлогын баримт бичгүүдтэй нийцүүлэн “Газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөлтэй холбогдсон нарийвчилсан журам”-ыг шинэчлэн найруулж боловсруулах нь аж ахуй нэгжүүдэд шинээр олгох, олгогдсон тусгай зөвшөөрөлд хяналт тавих, зохицуулалт хийх зэрэг чухал ач холбогдолтой байна.